ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/006/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууняам Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1616
танай _____-ны №_____-т

ГЭР, БҮЛ ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 322,510.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Чингис Хаан банкинд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 94,916.9 сая төгрөгөөс тайлант онд 1.6 хувь буюу 1,517.7 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 93,399.2 сая төгрөгийн авлага барагдаагүй эрсдэлтэй;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах нийт 68,201.5 сая төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдлээс 3.7 хувь буюу 2,500.0 сая төгрөгийг барагдуулж, 65,701.5 сая төгрөгийг барагдуулах ажил удаашралтай;
- Олон жилийн насжилттай 6,444.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дугаар зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Нийгмийн

даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 29 дүгээр зүйлийн 29.4, 37 дугаар зүйлийн 37.13.5, 37.14.4, 45 дугаар зүйлийн 45.1 холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 120 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 500.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 785.6 мянган төгрөг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авахад тайлант онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 199/НД73/24 дугаартай гэрээг Сангийн яамтай байгуулж 1 жилийн хугацаатай 100,000.0 сая төгрөгийн үнэт цаасыг 8.5 хувь, 2 жилийн хугацаатай 100,000.0 сая төгрөгийн үнэт цаасыг 9 хувь, 3 жилийн хугацаатай 100,000.0 сая төгрөгийн үнэт цаасыг 9.5 хувийн хүүтэй тус тус худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхээр баталжээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орсон байна.Тухайлбал: Нийгмийн даатгалын хуваарилалтын зарчмаас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих, даатгуулагчийн нэрийн дансны хийсвэр бичилтийг үе шаттайгаар мөнгөжүүлэх, даатгуулагчийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах сонголтоо хийх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, хуримтлалын нэгдсэн сангийн хуулийн хүрээнд мөнгөжүүлсэн орлогыг эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд ашиглах боломжтой зохицуулалт, сайн дураар даатгуулагч малчны 5 хүртэл жилийн шимтгэлийн 50 хувийг төрөөс төлөх, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан жил бүрийн 1 дүгээр сараас нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид протез, ортопедийн зардлын төлбөрийн жишиг үнийг баримтлан 3 жил тутамд 100 хувиар тооцож олгох, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч

байгаа сайн дураар даатгуулагч эх/эцэг/-ийн шимтгэлийг төрөөс төлөх зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		**1,946,222,432.0**	**2,170,997,547.4**
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,248,356,387.3	1,430,750,807.3
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	680,505,967.6	726,713,755.3
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	17,338,477.1	13,532,984.8
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	21,600.0	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		**34,529,913.5**	**300,000,000.0**
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	-	300,000,000.0
Үнэт цаас		-	300,000,000.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	34,529,913.5	-
Биет хөрөнгө		32,373,661.0	-
Биет бус хөрөнгө	13	2,156,252.6	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		**1,980,752,345.5**	**2,470,997,547.4**
НИЙТ ӨР ТӨЛБӨР		**46,350,007.1**	**89,138,145.2**
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	46,350,007.1	89,138,145.2
Өглөг	17а, 17б	7,281,365.9	37,431,648.5
Урьдчилж орсон орлого	18а, 18б	39,068,641.2	51,706,496.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		**1,934,402,338.4**	**2,381,859,402.1**
Засгийн газрын хувь оролцоо		1,934,402,338.4	2,381,859,402.1
Засгийн газрын оруулсан капитал		12,216,142.7	-
Хуримтлагдсан үр дүн		1,917,803,452.2	2,381,859,402.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,419,322.6	-
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		(36,579.0)	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		**1,980,752,345.5**	**2,470,997,547.4**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		**4,797,875,133.4**	**5,670,831,220.1**
ТАТВАРЫН ОРЛОГО		4,186,992,091.0	4,440,903,987.7
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		4,186,992,091.0	4,440,903,987.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	23,977,857.1	38,732,883.5
Нийтлэг татварын бус орлого		23,977,857.1	38,732,883.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		586,905,185.3	1,191,194,348.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	**2а, 2б**	**4,688,654,320.6**	**5,128,513,099.3**
УРСГАЛ ЗАРДАЛ		4,688,654,320.6	5,128,513,099.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		45,719,246.2	1,002,941.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		32,608,610.0	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,062,334.9	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,280,093.6	-
Хангамж, бараа материалын зардал		1,060,780.3	-
Норматив зардал		-	-
Эд хогшил, урсгал засварын зардал		1,011,913.2	-
Томилолт, зочны зардал		374,458.0	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,435,607.0	789,660.7
Бараа үйлчилгээний бусад зардал		3,885,449.2	213,281.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,642,935,074.5	5,127,510,157.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		109,220,812.8	542,318,120.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	2,399.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		77,142.8	35,944,451.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		**109,143,670.0**	**506,376,068.7**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,827,238,168.7**	**-**	**1,827,238,168.7**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,979,500.2)	-	(1,979,500.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,825,258,668.5	-	1,825,258,668.5
Тайлант үеийн үр дүн	109,143,670.0	-	109,143,670.0
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,934,402,338.4**	**-**	**1,934,402,338.4**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(58,919,005.0)	-	(58,919,005.0)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,875,483,333.4	-	1,875,483,333.4
Тайлант үеийн үр дүн	506,376,068.7	-	506,376,068.7
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**2,381,859,402.1**	**-**	**2,381,859,402.1**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	**4,945,185,400.4**	**6,408,343,632.5**
ТАТВАРЫН ОРЛОГО	4,151,750,943.0	5,193,657,922.5
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	4,151,750,943.0	5,193,657,922.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,212,810.8	39,711,742.2
Нийтлэг татварын бус орлого	27,212,810.8	39,711,742.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	766,221,646.6	1,174,973,967.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**4,690,801,692.5**	**6,225,949,212.5**
УРСГАЛ ЗАРДАЛ	4,690,801,692.5	6,225,949,212.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,771,256.9	7,047,595.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,629,904.6	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,063,573.8	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,329,450.2	-
Хангамж, бараа материалын зардал	1,337,464.4	-
Эд хогшил, урсгал засварын зардал	1,145,919.4	-
Томилолт, зочны зардал	374,458.0	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,498,495.1	797,341.9
Бараа үйлчилгээний бусад зардал	391,991.4	6,250,253.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,648,030,435.6	6,218,901,616.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	**254,383,708.0**	**182,394,420.0**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	42,116.8	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**42,116.8**	**-**
Дотоод эх үүсвэрээр	**42,116.8**	**-**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	**(42,116.8)**	**-**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	**(10,030.3)**	**-**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	10,030.3	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	**254,331,560.9**	**182,394,420.0**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	994,024,826.4	1,248,356,387.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,248,356,387.3	1,430,750,807.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**5,121,171,153,700.00**	**5,104,705,126,647.23**	**16,466,027,052.77**	99.7
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**5,188,403,324,600.00**	**5,107,205,126,947.23**	**81,198,197,652.77**	98.4
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,058,726,000.00**	**797,341,927.09**	**261,384,072.91**	75.3
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**1,058,726,000.00**	**797,341,927.09**	**261,384,072.91**	75.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	745,069,500.00	519,001,667.09	226,067,832.91	69.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	313,656,500.00	278,340,260.00	35,316,240.00	88.7
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**5,187,344,598,600.00**	**5,106,407,785,020.14**	**80,936,813,579.86**	98.4
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**5,187,344,598,600.00**	**5,106,407,785,020.14**	**80,936,813,579.86**	98.4
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,187,344,598,600.00	5,106,407,785,020.14	80,936,813,579.86	98.4
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	**(67,232,170,900.00)**	**(2,500,000,300.00)**	**(64,732,170,600.00)**	3.7
230001	Эргэж төлөгдөх зээл	(67,232,170,900.00)	(2,500,000,300.00)	(64,732,170,600.00)	3.7
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**5,121,171,153,700.00**	**5,604,661,954,596.05**	**(483,490,800,896.05)**	109.4
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**1,174,973,967,800.00**	**1,174,973,967,800.00**	**-**	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,174,973,967,800.00	1,174,973,967,800.00	-	100.0
33	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**4,013,429,356,800.00**	**4,434,687,987,396.05**	**(421,258,630,596.05)**	110.5
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,013,429,356,800.00	4,434,687,987,396.05	(421,258,630,596.05)	110.5
37	**БУСАД ЭХ ҮҮСВЭР**	**(67,232,170,900.00)**	**(5,000,000,600.00)**	**(62,232,170,300.00)**	7.4
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(67,232,170,900.00)	(5,000,000,600.00)	(62,232,170,300.00)	7.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,248,349,327,255.91	(1,248,349,327,255.91)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,430,750,807,259.34	(1,430,750,807,259.34)	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**-**	**1,624,200.00**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,624,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,624,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,624,200.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,624,200.00
III	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**	**-**	**-**
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,624,200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,794,287.3 сая төгрөгийн 24 алдаа[1] илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 322,510.0 сая төгрөгийн 45 зөрчил[2] илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 169,633.8 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 9,424.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 143,451.1 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн нийт алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 322,510.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 270,626.0 сая төгрөгөөр их байгаа тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагууд:

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа газар, хэлтсийн үйл ажиллагааны болон сангийн 33 санхүүгийн тайланг нэгтгэснээс 13 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 15 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 1 санхүүгийн тайланд “Дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 221,322.6 сая төгрөгийн 17 алдааг илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 7,655.9 сая төгрөгийн 37 зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,286.4 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 5,368.8 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудлаар 39.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

“Хязгаарлалттай” болон “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” харьяа байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд анхаарч, нэгжийн дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Аудитаар нийт 314,854.1 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 167,347.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 9,424.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 138,082.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 2,572,964.7 сая төгрөгийн 7 алдааг илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудлаар 720,149.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Албан шаардлага

1) 1. Чингис хаан банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 94,916.9 сая төгрөгөөс тайлант онд 1,517.7 сая төгрөг буюу 1.6 хувийг барагдуулж, үлдэгдэл 93,399.2 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх гэрээний хэрэгжилт хангалтгүй, тайлант онд дансны үлдэгдлийн баталгаа гаргаж баталгаажуулсан боловч уг хөрөнгийг банкнаас гаргах боломжгүй бодит бус үлдэгдэлтэй хэвээр байна. Үүнд: Тус банканд байршиж буй үлдэгдлийн 95.29 хувь буюу 88,998.7 сая төгрөг ҮОМШӨ-ний даатгалын сангийн мөнгөн хөрөнгө, 4.70 хувь буюу 4,389.1 сая төгрөг нь тэтгэмжийн сангийн мөнгөн хөрөнгө, 0.01 хувь буюу 11.4 сая төгрөг нь ажилгүйдлийн сангийн мөнгөн хөрөнгө байна. Монгол банкнаас Чингис хаан банкийг татан буулгах шийдвэр гараагүй тул санхүү, бүртгэлд авлагаар бүртгэх эрх зүй бүрдээгүй, нийгмийн даатгалын сангийн хөрөнгө эрсдэлтэй байна.

2. СБД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны шийдвэрийн дагуу Чингис хаан банкинд байршиж буй дансны үлдэгдэлд тооцсон /2020 оны 08,09,10 саруудад/ хүүгийн авлагыг 1,801.9 сая төгрөгийг төлбөр барагдуулах дараалал хүлээгдэж байгаагаас шалтгаалан барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

> *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Чингис хаан банкинд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай, шүүхийн 2020 оны шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2) Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл 68,201.5 сая төгрөгийн авлагаас 3.7 хувь буюу 2,500.0 сая төгрөг барагдаж, үлдэгдэл 65,701.5 сая төгрөгийг барагдуулах ажил удаашралтай хэвээр байна. Үүнд: ҮОМШӨ-ний даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 62,023.0 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 3,677.0 сая төгрөг, капитал банкны түрээсийн авлага 1,545.6 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасантай нийцэхгүй байна.

> *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Капитал банканд байршиж байсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 65,701.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг тус банкны эрх хүлээн авагчтай хамтарч эрчимжүүлэх, авлагыг 20-иос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

3) Тайлант онд олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах 6,444.7 сая төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдлийг бууруулаагүй, хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч тайлант онд барагдуулалт хийгдээгүй. Тухайлбал:
1. Дампуурсан болон татан буугдсан 7 банкны нийт 5,446.1 сая төгрөгийн авлага /Сэргээн босголт банк 2,066.6 сая төгрөг, ХОТШ банк 1,582.2 сая төгрөг, Монгол даатгал-Ардын банк 824.5 сая төгрөг, Экзим банк 753.2 сая төгрөг, Монгол бизнес банк 200.0 сая төгрөг, Азийн хөрөнгө оруулалтын банк 19.6 сая төгрөг/,
2. 16 аж ахуй нэгжийн НДШ-ийн 909.8 сая төгрөгийн авлага /Тухайлбал: Нийслэлийн өмчийн газар 552.6 сая төгрөг, "Өндөр гэгээн" ХХК 111.7 сая, Дорнын говь ХХК 150.0 сая төгрөг/,
3. 15 иргэний НДШ-ийн 88.9 сая төгрөгийн авлага тус тус байна. Дээрх авлагуудыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн боловч хангалттай үр дүнд хүрээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:”, 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай нийцэхгүй байна.

> *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй, иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах авлагыг 20-иос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

4) Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын харьяа 33 байгууллагын НДС-гийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 228,978.5 сая төгрөгийн 54 алдаа, зөрчил илэрснээс 221,322.6 сая төгрөгийн 17 алдааг залруулга хийлгэж, залруулаагүй 7,655.9 сая төгрөгийн 37 зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих санхүү, бүртгэл хөрөнгө оруулалтын газрын хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Аудитаар 4 байгууллагын НДС-гийн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6.6.1.төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;”, 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх. 14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-д "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:, 37.13.5-д “нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> *<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Санхүү бүртгэлд тавих дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

5) Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд тусгасан 9,424.4 сая төгрөгийн нийт хөрөнгийн үлдэгдлийг тодорхойгүй байдал болон хамрах хүрээний хязгаарлалтаас шалтгаалж аудитор хангалттай, зохистой аудитын нотолгоог олж аваагүй, материаллаг байдал өргөн тархсан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-д "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

> *<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Татгалзсан” санал, дүгнэлт авсан холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 01:

Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох санхүүжилт хүрэлцээгүйгээс шалтгаалан тус сангаас даатгуулагчид олгох 2024 оны 11, 12 дугаар сарын ажилгүйдлийн тэтгэмжийн нийт 14,131.4 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн тэтгэмж авахыг хүссэн өргөдлийг энэ хуулийн 15.2-т заасан журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт хүлээж авснаас хойш хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж олгох асуудлыг 14 хоногийн дотор, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 24 цагийн дотор шийдвэрлэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

> *Өгсөн зөвлөмж*: Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тасарсан шалтгааныг тодорхойлж, орлогыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Илрүүлэлт 02:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгын хүрээнд даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар заажээ. Үүний дагуу НДЕГ-н дэргэдэх Мэдээлэл технологийн төвөөс тус хуулийн 29.3.1-д заасны дагуу мөнгөжүүлэх бэлэн орлогыг 1,020,305 даатгуулагчийн 336,579.6 сая төгрөгийг тооцсон байна. Уг тооцооллыг үндэслэн НДЕГ-аас тайлант онд тэтгэврийн нөөц санд нийт 212,628.7 сая төгрөгийг тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд төвлөрүүлж, тооцоолсноос 123,950.9 сая төгрөгөөр мөнгөжүүлсэн орлогыг дутуу байршуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн тухай 27 дугаар зүйлийн 27.6-д "Даатгуулагчийн энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, бүртгэсэн шимтгэлийн орлогод жил бүр хүү тооцож, бүртгэнэ.", 29 дүгээр зүйлийн 29.4-д "Энэ хуулийн 29.3-т заасан орлогыг даатгуулагч бүрээр хуваарилж, тэтгэврийн нөөц сангийн дансанд байршуулна.", 37 дугаар зүйлийн 37.14.4. "энэ хуулийн 29.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;", Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.3-д "Энэ журмын 2.2-т заасан орлогыг дараах байдлаар тэтгэврийн нөөц сангийн дансанд шилжүүлнэ: 2.3.1."Нийгмийн даатгалын ерөнхий газар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д заасан тухайн сарын шимтгэлийн орлогыг дараа сарын 15-ны өдрийн дотор;" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

> *Өгсөн зөвлөмж*: Тэтгэврийн нөөц санд дутуу байршуулсан мөнгөжүүлэхээр тооцсон орлогыг бүрэн байршуулж, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн алдаа, зөрчил

3.3.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл

Албан шаардлага

1) Анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсөв захирагчийн тушаал, шийдвэргүй Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн 5 гишүүнд олгосон мөнгөн урамшууллын нийт 7.3 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 11 дүгээр зүйлийн 11.1.2-д "санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх

хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3.3.2 Нийгмийн даатгалын төв сан

Албан шаардлага

1) 1. Өмнөх оны аудитаар өгсөн Капитал банкны эрх хүлээн авагчаас авлагад тооцож авсан хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоосон түрээсийн төлбөрөөс доогуур үнээр тогтоосон, гэрээг шинэчлээгүй зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Тайлант онд эрх хүлээн авагчаас авлага тооцуулан авсан оффисын зориулалттай байрыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоосон түрээсийн төлбөрийн доод хязгаараас доогуур түрээслүүлж, нийт 170.2 сая төгрөгийн түрээсийн орлого олох боломжийг алдаж, зөрчлийг давтан гаргасан. Үүнд: Сүхбаатар дүүргийн Сэлбэ амралтын газрын 3,240 м.кв газраас 156.8 сая төгрөг, Баянзүрх дүүргийн 16-р хороололд байршилтай худалдаа, үйлчилгээний чиглэлээр ашиглаж буй 226 м.кв газраас 8.4 сая төгрөг, мөн Баянзүрх дүүргийн 16-р хороололд байршилтай худалдаа, үйлчилгээний чиглэлээр ашиглаж буй 196 м.кв газраас 4.8 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох" зааврын 1 дэх хэсгийн 1-д “1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ Нийслэл, Улаанбаатарт Худалдаа, үйлчилгээ 15,000.0 төгрөг”, 8-д бусад 10,000.0 төгрөг", МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь:* Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон түрээсийн төлбөрийн доод хязгаарыг баримталж ажиллаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллага шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. /НД-ын Төв сан, Орхон аймгийн НДС, Завхан аймгийн НДС/

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж хэвших зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагч

Албан шаардлага

1) Өмнөх оны аудитаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авлагад тооцуулан хүлээн авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажлыг эрчимжүүлэх, сангийн эх үүсвэрийг бий болгох талаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд: Өмнөх оны үлдэгдэл 15,985.3 сая төгрөгийн 41 үндсэн хөрөнгөөс тайлант онд 12.6 хувь буюу 2,452.3 сая төгрөгийн 10 хөрөнгийг борлуулж, 13,533.0 сая төгрөгийн хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтай хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь*: Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээж авсан хөрөнгөөс 40-өөс доошгүй хувийг борлуулж, нийгмийн даатгалын төв санд мөнгөн хөрөнгөөр төвлөрүүлэх, худалдах-худалдан авах гэрээний дагуу борлуулсан хөрөнгийн гэрээний үүргийн хэрэгжилт, төлбөр барагдуулах хуваарьт хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2) Цар тахал буюу коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын шалтгаалан улс орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, аж ахуйн нэгж, байгууллагын орлого буурч, үйл ажиллагаа нь доголдож байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг дэмжих зорилгоор УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд "2020.02.01-2021.07.01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан/ 9 дүгээр зүйлийн 1,2,3,4,5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно." гэсэн заалтын дагуу ҮОМШӨ-ний даатгалын сангаас нийт 706,616.0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулснаас шалтгаалан цаашид тус сангаас зарцуулах тэтгэмжийг олгох эх үүсвэр дутагдах эрсдэл үүсэхээр байна. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн санд зарцуулсан 706,616.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагад хандсан боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.7.төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх; 14 дүгээр зүйлийн 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлж зарцуулсантай холбоотой алдагдал үүсэх эрсдэлийг урьдчилан тодорхойлж арга хэмжээ авч ажиллах шийдэл боловсруулах, албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

Илрүүлэлт 01:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг Монгол банкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж заасан боловч Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-205 дугаар тушаалаар баталсан "Төв банкны үнэт цаасны арилжааны журам"-д зөвхөн Монголбанкны үнэт цаасыг худалдан авахад арилжааны банк оролцох эрхтэй, мөн Төрийн сангийн дансанд НДС-ын мөнгөн хөрөнгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж хүү тооцуулах эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна. Үүнээс шалтгаалан Монголбанкны үнэт цаас худалдан авах болон Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах, түүнд хүү тооцох асуудал шийдвэрлэгдээгүй байна.
Энэ нь Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-205 дугаар тушаалаар баталсан "Төв банкны үнэт цаасны арилжааны журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.6-д "Төв банкны үнэт цаасны арилжааны хэлцлийг шаардлага хангасан банктай хийнэ:", 1.6.1-д "Төв банкны үнэт цаасны арилжааны ерөнхий гэрээнд нэгдэн орсон", 1.6.2-д "ТБҮЦ-ны арилжааны төлбөр тооцоог сүүлийн 6 сарын хугацаанд саатуулаагүй" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг Монголбанкны үнэт цаас болон Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

Илрүүлэлт 02:

- Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансанд 2024 онд тооцох хүүгийн хэмжээг НДҮЗ нь батлаагүйгээс шалтгаалан даатгуулагчийн тайлант оны нэрийн дансны хуримтлалын үлдэгдэл дутуу тооцоологдож, тэтгэвэр дутуу тогтоогдох эрсдэлтэй, мөн нэрийн дансны үлдэгдэл нь бодит бус бүртгэл хэлбэрээр байна.
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.5-д “даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд хөрөнгө оруулж болно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6-д "Даатгуулагчийн энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, бүртгэсэн шимтгэлийн орлогод жил бүр хүү тооцож, бүртгэнэ.", 27.7-д "Энэ хуулийн 27.6-д заасан тухайн жилийн хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтийг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно:", 29.5-д "Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн доор дурдсанаар хөрөнгө оруулж болно:", 29.5.2-д "тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тэтгэврийн даатгалын нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг хуульд заасан хугацаанд багтаан баталж байх, мөнгөжүүлсэн орлогыг хөрөнгө оруулалтын байдлаар ашиглах сонголтын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

Илрүүлэлт 03:

Нийгмийн даатгалын сангийн Тэтгэврийн даатгалын санд 3,573,080.8 сая төгрөгийн орлого төвлөрч, 4,666,516.4 сая төгрөгийг зарцуулж, 1,093,435.7 сая төгрөгийн алдагдлыг, улсын төсвийн татаас 1,169,792.4 сая төгрөгөөр санхүүжүүлж, тэтгэврийн сангийн үлдэгдэл 76,356.7 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

> *Өгсөн зөвлөмж:* Хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс тэтгэврийн даатгалын сангийн алдагдалтай харилцан хамааралтай байгаа эсэхэд шинжилгээ хийж хамааралтай хүчин зүйлийг тодорхойлох.

Нийгмийн даатгалын төв сан

Албан шаардлага

1) 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /хуучин нэрээр/, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь “Ай Ти Зон” ХХК-тай “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх” ажлын гэрээг 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдөр 2 жилийн хугацаанд гүйцэтгэхээр байгуулсан боловч систем нь бүрэн хийгдэж дуусаагүй байхад 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн байна. Уг системийг хэрэглээнд нэвтрүүлснээс иргэн, аж ахуйн, нэгж байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулан дараах хүндрэлүүд үүсгэсэн байна. Тухайлбал: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасан даатгуулагчид олгогдох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлөлт зэрэг асуудлуудыг хугацаа алдаж шийдвэрлэгдсэн байна.

2. Санхүүгийн тайлангийн "SICOS" программаас нийгмийн даатгалын сангийн авлага, өглөгийн бүртгэлийн дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний журнал, ерөнхий журнал нэгтгэгдэж татагддаггүй /данс тус бүрээр татагддаг/, санхүүгийн тайлан бэлтгэн гаргахад ажил гүйлгээнүүд журнал бичилтэд бүрэн холбогдоогүй гараар шивж оруулсан зэрэг хүндрэлүүд үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-д "журналд бичих;", 14.3.3-д "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас батлагдсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн.", 17 дугаар зүйлийн 17.2-д "Нийгмийн даатгалын байгууллага энэ хуулийн 17.1-д заасан мэдээллийг судалгаа, шинжилгээ, үнэлгээ, хэтийн тооцоолол, хяналт шалгалт хийх, мэдээ, тайлан гаргах, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор ашиглана.", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон “Ай Ти Зон” ХХК хооронд байгуулсан 2019 оны 07 дугаар сарын N-09/17 дугаартай гэрээний 14.1-д “Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь:* Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн системтэй холбоотой алдаа, доголдолтой, дутуу гүйцэтгэсэн асуудалд шаардлагатай хөгжүүлэлтийг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлж хүлээн авах, хяналт хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалын мэдээллийн систем болон санхүүгийн тайлангийн “SICOS” программыг бүрэн дуусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2) Өмнөх оны аудитаар өгсөн 2006 оноос хуримтлагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 39.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь:* Өмнөх оны аудитаар өгсөн 39.5 сая төгрөгийн өглөгийн эзэн холбогдогчийг тогтоон тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

5.1. Аудитаар Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 2,794,287.3 сая төгрөгийн 24 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
I.Төсвийн ерөнхийлөн захирагч													
1	Нийгмийн даатгалын сангийн үндэсний зөвлөлийн дарга	7	2,572,964.7			7	2,572,964.7	7	2,572,964.7				
	ТЕЗ дүн	**7**	**2,572,964.7**			**7**	**2,572,964.7**	**7**	**2,572,964.7**				
II.Төсвийн шууд захирагч													
1	Нийгмийн даатгалын төв сан	**1**	**340.6**		-	1	340.6	1	340.6				
2	Архангай аймгийн нийгмийн даатгалын сан	**2**	**12.5**	1	3.0	1	9.5	2	12.5				
3	Дорноговь аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**686.6**		-	1	686.6	1	686.6				
4	Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**51.2**	1	51.2		-	1	51.2				
5	Орхон аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**739.3**		-	1	739.3	1	739.3				
6	Өмнөговь аймгийн нийгмийн даатгалын сан	**3**	**48,356.4**		-	3	48,356.4	3	48,356.4				
7	Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**8.1**		-	1	8.1	1	8.1				
8	Завхан аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**206.6**		-	1	206.6	1	206.6				
9	Төв аймгийн нийгмийн даатгалын сан	**6**	**170,921.3**	1	31,925.7	5	138,995.6	6	170,921.3				
	ТШЗ дүн	**17**	**221,322.6**	**3**	**31,979.9**	**14**	**189,342.7**	**17**	**221,322.6**	**-**	**-**	**-**	**-**
	Дүн	**24**	**2,794,287.3**	**3**	**31,979.9**	**21**	**2,762,307.4**	**24**	**2,794,287.3**	**-**	**-**	**-**	**-**

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 322,510.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 169,633.8 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 9,424.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 143,451.1 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
	А										
	I.Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга	**8**	**314,854.1**	-	-	4	167,347.4	1	9,424.4	3	138,082.3
	ТЕЗ дүн	**8**	**314,854.1**	**-**	**-**	**4**	**167,347.4**	**1**	**9,424.4**	**3**	**138,082.3**
	II.Төсвийн шууд захирагч										
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба	**1**	**7.3**			1	7.3				
2	Нийгмийн даатгалын төв сан	**1**	**170.2**			1	170.2				
3	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг	**-**	**-**								
4	Архангай аймгийн нийгмийн даатгалын сан	**2**	**5.6**			2	5.6				
5	Баян-өлгий аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**	-	-	-	-	-	-	-	-
6	Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
7	Булган аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**16.0**							1	16.0
8	Говь-Алтай аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**	-	-	-	-	-	-	-	-
9	Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
10	Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**0.7**	1	0.7						
11	Дорноговь аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
12	Дорнод аймгийн нийгмийн даатгалын сан	**4**	**1,103.6**			1	-			3	1,103.6
13	Дундговь аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
14	Завхан аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**145.8**							1	145.8
15	Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**-**							1	-
16	Орхон аймгийн нийгмийн даатгалын сан	**3**	**0.4**							3	0.4
17	Өвөрхангай аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**179.2**			1	179.2				
18	Өмнөговь аймгийн нийгмийн даатгалын сан	**3**	**3,647.6**							3	3,647.6
19	Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын сан	**2**	**205.2**			2	205.2				
20	Төв аймгийн нийгмийн даатгалын сан	**4**	**1,587.4**			3	1,586.9			1	0.5
21	Увс аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
22	Ховд аймгийн нийгмийн даатгалын сан	**2**	**183.8**							2	183.8
23	Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
24	Хэнтий аймгийн нийгмийн даатгалын сан	**1**	**131.9**			1	131.9				
25	Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын сан	**3**	**1.9**							3	1.9

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

26	Багануур дүүргийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**	-	-	-	-	-	-	-	-
27	Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
28	Налайх дүүргийн нийгмийн даатгалын сан	**2**	**0.5**							2	0.5
29	Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сан	**1**	**161.7**							1	161.7
30	Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын сан	**1**	**-**							1	-
31	Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
32	Багахангай дүүргийн нийгмийн даатгалын сан	**2**	**107.0**							2	107.0
33	Сонгино хайрхан дүүргийн нийгмийн даатгалын сан	**-**	**-**								
	Төсвийн шууд захирагчийн дүн	**37**	**7,655.9**	**1**	**0.7**	**12**	**2,286.4**	**-**	**-**	**24**	**5,368.8**
	Нийт	**45**	**322,510.0**	**1**	**0.7**	**16**	**169,633.8**	**1**	**9,424.4**	**27**	**143,451.1**

5.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой нийт 720,188.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 720,188.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	I. Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	4	720,149.0			2	720,149.0			2	-
	ТЕЗ дүн	**4**	**720,149.0**	**-**	**-**	**2**	**720,149.0**	**-**	**-**	**2**	**-**
	II. Төсвийн шууд захирагч										
2	Нийгмийн даатгалын төв сан	3	39.5			2	39.5			1	-
3	Завхан аймгийн нийгмийн даатгалын сан	1	-				-			1	-
4	Орхон аймгийн нийгмийн даатгалын сан	1	-				-			1	-
5	Төв аймгийн Нийгмийн даатгалын сан	1	-				-			1	-
	ТШЗ дүн	**6**	**39.5**	**-**	**-**	**2**	**39.5**	**-**	**-**	**4**	**-**
Дүн		**10**	**720,188.5**	**-**	**-**	**4**	**720,188.5**	**-**	**-**	**6**	**-**

6. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
			Санал дүгнэлт гаргасан	Аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн	Аудит хийгдээгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
1	Төсвийн шууд захирагч	33	20	13	-	15	4	-	1
2	Төсвийн ерөнхийлөн захирагч	1	1	-	-	-	1	-	-
Нийт		**34**	**21**	**13**	**-**	**15**	**5**	**-**	**1**